



## МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Мөнгөний бодлогын шийдвэрийн тухай

**Дугаар: 2015/02**

**Мөрдөх огноо: 2015 оны 4 дүгээр сарын 10**

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр ээлжит хуралдаанаа хийж, мөнгөний бодлогын хүүг одоогийн түвшинд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт үргэлжлэн буурч хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн жилийн инфляци 2015 оны 3 дугаар сарын эцэст 9.3 хувь болж буурлаа. Суурь инфляци 11.9 хувь буюу өндөр хэвээр байгаа хэдий ч, эрэлтийн гаралтай инфляци 2015 онд нэмэгдэхээргүй байгаа тул оны эцэст инфляцийн зорилтот түвшинд хүрэхээр байна.

Бодлогын энэхүү шийдвэр нь төгрөгийн өгөөжийг хадгалах, богино хугацаанд урсгал тэнцлийн алдагдлыг бууруулах, инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжихэд эергээр нөлөөлснөөр дунд, урт хугацаанд эдийн засаг тогтвортой өсөх орчинг бүрдүүлнэ.

Зөвлөлийн хурлын хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ